# “Эмэгтэйчүүд Бид Бол Ус” 2021 оны Аяны Ажил

**Нийгмийн сүлжээн дээрээ ус хамгаалагч эмэгтэйчүүдийн дуу хоолойг өсгөцгөөе.**

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөс (3-р сарын 8) Дэлхийн Усны Өдөр (3-р сарын 22) хүртэл **уур амьсгалын өөрчлөлтийн хүрээнд усны аюулгүй байдлыг хангахын төлөө тэмцэж буй эмэгтэйчүүдийн үүрэг, тэдний тавьж буй шаардлага болон үйл ажиллагааг** онцлох зорилгоор бидэнтэй нэгдээрэй. Бид өдөрт нэгээс хоёр түүхийг нийгмийн сүлжээн дээр постлох бөгөөд эдгээр нь **олборлох үйл ажиллагаа, уур амьсгалын худал хуурмаг шийдвэр болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд оролцож буй компаниуд, засгийн газрууд болон хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааны** улмаас усны эх үүсвэр ундарга нь ширгэж, эсвэл бохирдсон Африк, Ази болон Латин Америк дахь ЖНҮАДЭ-ийн дэмжиж ажилладаг олон нийтэд анхаарлаа хандуулах юм.

Аяны зорилго нь **эмэгтэйчүүдийн манлайлан удирддаг олон нийтэд түшиглэсэн байгууллага, зохион байгуулалт болон дадал практикын уян хатан чанарыг** онцлохын зэрэгцээ дээрх оролцогч талуудын үйл ажиллагаа нь усны аюулгүй байдал алдагдаж, ус бохирдоход хүргэдгийг олон нийтэд ойлгуулах явдал юм. Хамтдаа бид тэднээс дараах ажлуудыг хийхийг шаардаж байна:

- **Эмэгтэйчүүдийн усны эрхийг зөрчиж буй** шатах ашигт малтмалын үйлдвэрлэлээс татгалзах.
- Жендэрийн шударга уур амьсгалын шийдлүүдээр **дамжуулан эмэгтэйчүүдийн усны эрхийг баталгаажуулах**. *Шийдлүүд нь эмэгтэйчүүд, уугуул иргэд болон орон нутгийн олон нийтийн үзэл бодол, зөвшөөрөл өгөх болон хяналтын хүрээнд тогтвортой, соёлын хувьд зохимжтой байх ёстой.*
- **Усны хүртээмж, менежмэнт, нөхөн сэргээлт болон хамгаалалтын хүрээнд** эмэгтэйчүүдийн тавих шаардлага, хэрэгцээ шаардлага, дадал практик болон санал хүсэлтийг тусгах.

Бидний шаардлагыг өргөн хүрээнд таниулахын тулд дээрх мессэжүүдийг нийгмийн сүлжээнд постлож, шейрлэж, цааш нь түгээнэ үү. Аяны ажлын мэдэгдлийг бүхлээр нь Индонезийн Бахаса, Англи, Филиппин, Франц, Гүрж, Хинди, Монгол, Непал, Португаль болон Испани хэл дээр тухайн холбоосоор орж харж болно.

**Постлох цагийн хуваарь, нийгмийн сүлжээн дээрх мессэжүүд болон график/зургийн холбоосуудыг** дор дурдсан. Мөн Гүүгл Слайд дээр график/зургууд байгаа ба эдгээрийг өөрсдийн агуулга, нөхцөл байдалд тохируулан өөрчлөхдөө мессэжийг эх хэл дээрээ буулгаж, байгууллагынхаа логог оруулна.

Асуулт байвал ЖНҮАДЭ-ийн харилцаа холбооны стратегич Рани Робелус руу GAGGAcommunication@fcmujeres.org хаягаар цахим шуудан илгээнэ үү.

**Хаштагууд**

**#WeWomenAreWater (#ЭмэгтэйчүүдБидБолУс)**
#WaterIsaHumanRight (#УсБолХүнийЭрх)
#SheDefends (#ТэрЭмэгтэйТэмцэгч)
#ClimateJustice (#УурАмьсгалынШудрагаЁс)
#GenderJustice (#ЖендэрийнШудргаЁс)

**#MujeresSomosAgua** #WHRD (#ХЭХЭ)
#DefendTheDefenders (#ХамгаалагчдыгХамгаал)
#KeepItInTheGround (#ГазартНьҮлдээ)
#Divest / #DivestFossils (#Татгалз / #ШатахАшигтМалтмалаасТатгалз)
#ShiftThePower (#ЭрхМэдлийгШилжүүл)

**3-р сарын 8: #IWD2021 #InternationalWomensDay буюу #ОлонУлсынЭмэгтэйчүүдийнӨдөр**
**3-р сарын 14, Далангийн эсрэг болон Голуудын төлөөх үйл ажиллагааны Олон улсын өдөр**: #RiversUniteUs буюу #ГолуудБиднийгНэгтгэдэг
**3-р сарын 19, Уур амьсгалын дэлхийн бослого**: #FaceTheClimateEmergency буюу #УурАмьсгалынОнцБайдалтайНүүрТул #NoMoreEmptyPromises буюу #ХоосонАмлалтааЗогсоо #GlobalClimateStrike буюу #УурАмьсгалынДэлхийнБослого
**3-р сарын 21**: #InternationalDayOfForests буюу #ОлонУлсынОйнӨдөр
**3-р сарын 22**: #WorldWaterDay буюу #ДэлхийнУсныӨдөр

Твиттер дээр биднийг @GAGGA_Alliance гэж тагласнаар бид таны постыг дахин жиргэх болно.

**График/зургууд**

Өөрийн **Твиттер хуудасны толгой зурагт зориулж** аяны ажлын имижийг **Англи**, **Испани хэл дээр** эндээс татаж авна.
Өөрийн **Фейсбүүкийн ковер зурагт зориулж** аяны ажлын имижийг **Англи**, **Испани хэл дээр** эндээс татаж авна.

Өөрсдийн агуулга, нөхцөл байдалтай уялдуулж өөрчлөн ашиглаж болох **аяны ажлын бүх мэдээллийн график/зургуудыг эндээс авна**. Ингэхдээ эмэгтэйчүүд, ус болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мессэжүүдийг эх хэл дээрээ буулгаж, байгууллагынхаа логог оруулна. Та бүхэн доорх постлох цагийн хуваарьт дурдсан мессэжүүд болон энэхүү баримт бичгийн эцэст дурдсан нэмэлт мессэжүүдийг аяны ажилдаа ашиглаж болно. Харамсалтай нь түүх бүрийг үгээр өгүүлэн илэрхийлэх боломжгүй учраас тухайн түүхийг гэрэл зургаар дүрсэлсэн.

# Пост хийх цагийн хуваарь

| **Түүхийн холбоосууд** | **Санал болгох мессэжүүд** | **График** | **Огноо ба цаг** |
|---|---|---|---|
| Аяны ажлын мэдэгдэл | Энэ жилийн #ОУЭӨ2021 #УурАмьсгалын өөрчлөлтийн хүрээнд усны төлөө тэмцэж буй эмэгтэйчүүдийн үүрэг, тэдний шаардлага болон үйл ажиллагааг онцлох зорилгоор 3-р сарын 8-22-ны өдрүүдэд бидэнтэй нэгдээрэй. З/газрууд, корпорациуд & хөрөнгө оруулагчид олон нийтийн хэрэгцээний усыг ширгээж, бохирдуулах нь дэндлээ (1/2)<br><br>Тэд бидний шаардлагын хариуд арга хэмжээ авах цаг болсон:<br><br>💸 Шатах ашигт малтмалаас #татгалз<br>♀️ Жендэрийн шударга уур амьсгалын шийдлүүдийг хэрэгжүүл<br>🚰 Эмэгтэйчүүдийн санал, хүсэлтийг тусга<br><br>Хүний эрх болох усаар хангагдах эрхийг хүн бүрт эдлүүлэхийн төлөө энэ мессэжийг шейр хийж, бидэнтэй нэгдэнэ үү. #WeWomenAreWater буюу #ЭмэгтэйчүүдБидБолУс #IWD2021<br>https://bit.ly/3bnEAZv<br><br>*(График дээрх таг: @GAGGA_Alliance)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 5/8<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Гондурасын эмэгтэйчүүд олборлох үйлдвэрийн эсрэг эв нэгдлээ илэрхийлж нэхмэл сүлжив | Цартахлын үеэр Эта болон Йота далайн шуургад өртсөний дараа Гондурасын Сула хөндийн эмэгтэйчүүд үндэстэн дамнасан компаниудын төв гэгдэх энэ газар усан цахилгаан станц барихыг эсэргүүцэж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс #ОУЭӨ2021<br><br>http://bit.ly/3sNxDXB<br><br>*(Твиттерийн график дээрх таг: @fcmujeres @GAGGA_Alliance Фейсбүүк дээрх графикийн таг: @mas.sb.hn @fcmujeres)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 8 Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |
| Эмэгтэйчүүд Нигерийн Дельта мужид мангро модны ойг нөхөн сэргээж байна - Нигери улс | Нигерийн Дельта нь мангро модны ойгоор дэлхийд 3-т тооцогдох том ой бөгөөд халуун бүсийн ойтой харьцуулахад 4 дахин их нүүрстөрөгч агуулдаг ч, нефтийн алдагдал болон нипа зэргээс шалтгаалж ирэх 50 жилд устаж алга болох төлөвтэй байна. Иймээс нутгийн эмэгтэйчүүд тэмцэж байна. 🌱 #ЭмэгтэйчүүдБидБолУс<br><br>http://bit.ly/3rh8Mv0<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @GAGGA_Alliance @lokiakawomen @MamaCash Фейсбүүк дээрх графикийн таг: @Lokiaka Centre, @Mama Cash Инстаграм дээрх графикийн таг: @mamacashfund)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 9:<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Өмнөд Африкын эмэгтэйчүүд: КОВИД-19-ын үед ус суурь эрх болох нь (Өмнөд Африк улс) | Өмнөд Африкын ган гачигт нэрвэгдсэн бүс нутагт орон нутгийн нүүрсний уурхайн усан хангамжид ихэнх усыг ашигласнаар олон нийтийн ундны ус хорогдож, гол ширгэж байна. 200 гаруй орон нутгийн олон нийтээс бүрдэх ИНБ-ууд болон эмэгтэйчүүд эдгээр усны төлөө тэмцэж, засгийн газартаа шаардлага тавьж байна. 👇<br><br>http://bit.ly/3bfj4q3<br><br>#ЭмэгтэйчүүдБидБолУс<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @WoMin_Africa @GAGGA_Alliance*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @womin.africa*<br>*Инстаграм дээрх графикийн таг: @womin.africa)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 10<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Боливийн Чикитания ойн түймрийн үеэр эмэгтэйчүүд хүний амь аварч байна (Боливи улс) | Хөдөө аж ахуйн үйлдвэрийн ашиг сонирхолын улмаас гарсан Боливийн Чикитанияд нүүрлэсэн ойн түймэр нь аль хэдийнэ хомс болсон усыг бохирдуулжээ. Түймрийн үеэр хүний амь аврахаар тэмцэж буй эмэгтэйчүүд усны хүртээмж, нөхөн сэргээлт болон эмх замбараагүй мод бэлтгэхийг зогсоохыг шаардаж байна. http://bit.ly/2OJ4JsN #ЭмэгтэйчүүдБидБолУс<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @ColectivoCasa @Fondo_ApthapiJ @GAGGA_Alliance*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @ColectivoCASABolivia @fondodemujeresbolivia)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 11<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |
| Бид эквалиптыг идэхгүй: Комын эмэгтэйчүүд газар нутгаа хамгаалж үлдэхийн төлөө зохион байгуулалтад оров (Парагвай улс) | Парагвай улсын Чако дахь эмэгтэй урчуудын байгууллага нь эквалиптын тариалан усны нөөцөд заналхийлэл учруулж байгааг анзаарч хариуцсан байгууллагын үйл ажиллагааг түр зогсоож, нутгийн ой модыг сүйтгэхээс урьдчилан сэргийлж чаджээ. #ЭмэгтэйчүүдБидБолУс<br><br>http://bit.ly/3bZRSdY<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @fmujeresdelsur @GAGGA_Alliance*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @fmujeresdelsur*<br>*Инстаграм дээрх графикийн таг: @fmujeresdelsur)* | | |

| | | | |
|---|---|---|---|
| Маунт Сламетын эмэгтэйчүүд газрын гүний дулааны төслийн эсрэг тэмцэж байна (Индонез улс) | Индонезийн Жава дахь орон нутгийн олон нийтийн хувьд амжиргаа нь гол горхи, урсгал уснаас хамааралтай байдаг учраас газрын гүний дулааны эрчим хүчний төсөл усыг нь бохирдуулснаас болж орлогоо алдахад хүрчээ. Нутгийн эмэгтэйчүүд тус төслийг зогсоохыг шаардаж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3t0WJT4<br><br>*(График дээрх таг: @GAGGA_Alliance*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг:* @aksiforjustice*)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 12<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |
| Мазвихва дахь алтны уурхай (Зимбабве улс) | Алтны уурхайгаас ялгарах химийн хорт бодисууд Зимбабве улсын нэгэн хуурай газрын олон нийтийн цорын ганц усны эх үүсвэрийг бохирдуулжээ. Цэвэр усаар хангахын тулд эмэгтэйчүүд цооногийг засч, шинэ цооног өрөмдүүлэхийн тулд орон нутгийн уул уурхайд нөлөөлж лобби хийж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3rHKzOP<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @IAFN_RIFA @GAGGA_Alliance*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @RedInternacionaldeForesteriaAnaloga* @MuondeTrust<br>*Инстаграм дээрх графикийн таг: @foresteria_analoga)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 13<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Юумаогийн эмэгтэйчүүд Роситасын далангийн эсрэг тэмцэж байна (Боливи улс)<br><br><br><br><br><br><br><br>К‘екчи‘ эмэгтэйчүүд “газрын цусыг” хамгаалж байна (Гватемал) | Боливи дахь Роситасын усан цахилгаан станцын төсөл нь ихэнхдээ ой мод бүхий 45,000 га газрыг үерт автуулж, 500 гаруй нутгийн өрхүүдэд сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна. Орон нутгийн эмэгтэйчүүд манлайлж шүүхэд хандсаны ачаар тус төслийг гацааж чаджээ. #ЭмэгтэйчүүдБидБолУс #ГолуудБиднийгНэгтгэдэг #DayofAction2021 #RightsofRivers<br><br>http://bit.ly/3sGkgsi<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @fundo_casa @SemillaBOLIVIA @GAGGA_Alliance<br>Фейсбүүк дээрх графикийн таг: @fundocasasocioambiental<br>Инстаграм дээрх графикийн таг: fondosocioambientalsemilla @fundocasasocioambiental)*<br><br>Гватемал улсын Санта Мария Кахабоны К’екчи’ эмэгтэйчүүд олон нийтийн манлайлагчдад ял шийтгэл оноож, эрүүгийн гэмт хэрэгт татаж байхад тэдний усны үндсэн бөгөөд ариун эх сурвалж болох “голуудыг устгаж буй” усан цахилгаан станцын төслүүдийн эсрэг тэмцэх галын шугаманд зогсч байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс #DayofAction2021 #RightsofRivers #ГолуудБиднийгНэгтгэдэг http://bit.ly/38BcN6b<br><br>*(График дээрх таг: @CMadreSelva @GAGGA_Alliance<br>Фейсбүүк дээрх графикийн таг: @MadreSelvaColectivo)* | Графикийг эндээс харна уу.<br><br><br><br><br><br><br><br><br><br><br><br>Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 14 Далангийн эсрэг болон Голуудын төлөөх үйл ажиллагааны Олон улсын өдөр 11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Адваси эмэгтэйчүүд Заварын Цайрын Уурхайн эсрэг тэмцэж байна (Энэтхэг улс) | Энэтхэгийн Заварын цайрын уурхайд ойрхон амьдардаг Адваси эмэгтэйчүүд уурхайн нөлөөгөөр ус нь харлаж бохирдсоноор ургац багасч, эрүүл мэндийн асуудал үүссэнийг анзаарчээ. Тэд зохион байгуулалтад орж, эрхээ ойлгосны үндсэн дээр чангаар тэмцэж эхэлжээ. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3vjDFkR<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @DhaatriC @GAGGA_Alliance @WomenWama*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @dhaatrirc*<br>*Инстаграм дээрх графикийн таг: @Dhaatrirc)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 15<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Гватемалын орон нутгийн залуу феминистууд урлагаар дамжуулан Монтагуа голыг хамгаалж байна | Ойгүйжилт, уул уурхайн болон орон нутгийн алдаатай менежмэнт нь Гватемал дахь Монтагуа голыг сүйтгэж байна. Орон нутгийн залуу феминистүүдийн бүлэг нь урлагаар дамжуулан олон нийтийг зохион байгуулалтад оруулж, гол горхи болон нутгийн эмэгтэйчүүд, хүүхэд залуусыг хамгаалж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3tnjC39<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @GAGGA_Alliance @FRIDAfund*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @FRIDAfund @adejumizabal1*<br>*Инстаграм дээрх графикийн таг: @fridafund @adejumizabal1)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 16<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Монголд говийн эмэгтэйчүүд нүүрсний уурхайг зогсоохоор нэгджээ | Монгол улсын Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй нүүрсний уурхай нь цахиурыг нүүрснээс салгахын тулд ундны усыг ашигласан учраас нутгийн 14 гол устаж алга болжээ. Сөрөг нөлөөлд өртсөн 200 өрхийг төлөөлөх эмэгтэйчүүдийн бүлгүүд уурхайг зогсоож чаджээ.<br><br>#ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3cAwXhQ<br><br>*(График дээрх таг: @MONES2000 @GAGGA_Alliance<br>Фейсбүүк дээрх графикийн таг: @MongolianWomensFund<br>Инстаграм дээрх графикийн таг: @mones2000)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 17<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |
| Боливийн хойд хэсэг Амазоны сав газар дахь чичирхийллийн хайгуул | Боливийн Амазон сав газарт газрын тосны чичирхийллийн хайгуулын улмаас нуур ширгэж, температур нэмэгдсэн учраас орон нутгийн олон нийтийн хүнсний гол эх сурвалж болох загас хорогдож байна. Нутгийн уугуул эмэгтэйчүүд усны төлөө шаардлага тавьж хамтдаа тэмцэж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/2Q7oYBc<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @FAU_LAC @GAGGA_Alliance<br>Фейсбүүк дээрх графикийн таг: @FondoAccionUrgenteLAC<br>Инстаграм дээрх графикийн таг: @FondoAccionUrgenteal)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 18<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Газрын тос олборлох үйл ажиллагаанаас хордсон Энтре Риос Гол (Боливи улс) | Усны хомсдол болон нефть ус, голыг бохирдуулж байгаа асуудалтай тулгарсан Боливийн Энтре Риосын эмэгтэйчүүд үр өгөөжтэй байдлаар ус ашиглах, усны менежмэнт хийх болон ус нөөцлөх танк барих талаар сургалт зохион байгуулж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3vDt9Fe<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @fmujeresdelsur @GAGGA_Alliance*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @fmujeresdelsur*<br>*Инстаграм дээрх графикийн таг: @fmujeresdelsur)* | | 3-р сарын 19 Ирээдүйн төлөө Баасан гарагууд Уур амьсгалын шударга ёсны төлөө дэлхийн тэмцэл<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Чорти эмэгтэйчүүд өвөг дээдсийнхээ үлдээсэн газар нутгаа эзэмшихээр тэмцэж байна (Гватемал улс) | Сүүлийн 17 жилийн хугацаанд Гватемалын Чорти уугуул иргэд өвөг дээдсийнхээ амьдарч байсан бөгөөд одоо өөрсдийн амьдарч буй газраа эзэмшихийг хүсч байна. Тариаланчид болон засгийн газар нь усны хүртээжээр хомс байгаа энэ үед тухайн олон нийт өөр шийдлийг эрэлхийлж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3cIq6Tq<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @TierraVivagt @GAGGA_Alliance*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @TierraVivaGuatemala)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 20<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |
| Вилла Монтесын эмэгтэйчүүд орон нутгийн усны тухай хуулийг санал болгож байна (Боливи улс) | Цартахлын үед усны хомсдол болон нүүрсустөрөгчийн бохирдлын хариу арга хэмжээ болгож Боливийн Вилла Монтесийн эмэгтэйчүүд өрхүүдэд борооны усыг хураах хүргэх системтэй болгох орон нутгийн төрийн бодлогыг санал болгож байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс http://bit.ly/3cVG5Oq<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @GAGGA_Alliance @ccimcattarija*<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @ccimcat*<br>*Инстаграм дээрх графикийн таг: ccimcat_org)* | Графикийг эндээс харна уу. | |

| | | | |
|---|---|---|---|
| Бидэнд ус өгдөг Мадре де Диос ойг хамгаалах нь (Перу улс) | Перу улсын Мадре де Диос халуун бүсийн ойн моднууд нь сая сая хүмүүсийг усаар хангахад гол үүрэг гүйцэтгэдэг. Эмэгтэйчүүдийн манлайлан удирддаг @ArbioPeru байгууллага нь хөгжиж буй модны үйлдвэрээс тэднийг хамгаалж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс #ОлонУлсынОйнӨдөр http://bit.ly/389eS9e<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @GAGGA_Alliance @IAFN_RIFA* @ArbioPeru<br>*Фейсбүүк дээрх графикийн таг: @RedInternacionaldeForesteriaAnaloga*<br>*Инстаграм дээрх графикийн таг:* @foresteria_analoga @ArbioPeru*)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 21: Олон улсын ойн өдөр<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

| | | | |
|---|---|---|---|
| Олборлох үйлдвэрийн Махакам голд үзүүлж буй нөлөөлөл (Индонез улс) | Индонезийн 2 дахь том голын дагуух цагаан будааны тариалангийн талбай нь нүүрсний уурхай болон хувирч, орон нутгийн эргэн тойронд 200 гаруй орхигдсон нүүрсний уурхайд хүүхдүүд живж байна. Иймээс эмэгтэйчүүд нэгдэж, засгийн газрын эсрэг хуулийн акц явуулж байна. #ЭмэгтэйчүүдБидБолУс #ДэлхийнУсныӨдөр [холбоос]<br><br>*(Твиттер дээрх графикийн таг: @jatamnas @WomenWama @GAGGA_Alliance Фейсбүүк дээрх графикийн таг:* @JaringanAdvokasiTambang<br>*Инстаграм дээрх графикийн таг: @jatamnas)* | Графикийг эндээс харна уу. | 3-р сарын 22: Дэлхийн усны өдөр<br><br>11:00-16:00 цаг Төв Европын Цаг |

**Нийгмийн сүлжээн дээр түгээх мессэжийн хувилбарууд**

Дээрх график/зургуудыг өөрсдийн агуулга, нөхцөл байдалд тааруулж өөрчилж болох учраас эмэгтэйчүүд, ус болон уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мессэжүүдийг нэмж оруулна. Түүхүүд нь зөвхөн Англи, Испани болон Франц хэл дээр байгаа учраас та бүхний ашиглаж болох бусад мессэжүүдийг дор санал болгов:

- Шатах ашигт малтмалаас татгалзаж, жендэрийн шударга шийдлүүдэд хөрөнгө оруул *(өөрсдийн агуулга, нөхцөл байдлаас шалтгаалан "шатах ашигт малтмал"-ын оронд уур амьсгалын худал хуурмаг шийдлүүд, усан цахилгаан станцын эрчим хүч, газрын гүний дулаан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл гэх мэтийг оруулж болно)*
- Бүхнийг газар шороонд нь үлдээ, уснаас гараа тат
- Ус бол хүний эрх
- Цаг нь болсон – хүн бүрт цэвэр ус хүртээхийн төлөө
- Ус болон жендэрийн шударга ёсыг яг одоо!

· Бид уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг өөрсдийн ой мод, газар шороо болон усан дээр бэлхэнээ харж байна – шатах ашигт малтмалаас яг одоо татгалзаж, жендэрийн шударга шийдэлд хөрөнгө оруул.

· Эмэгтэйчүүд, уугуул иргэд болон орон нутгийн олон нийтийн үзэл бодол, зөвшөөрөл болон хяналтыг тусгасан жендэрийн шударга уур амьсгалын шийдлүүдийг яг одоо хэрэгжүүл.

· Эмэгтэйчүүдийн усны эрхийг яг одоо баталгаажуул. Усны хүртээмж, менежмэнт болон засаглалд эмэгтэйчүүдийн тавих шаардлага, хэрэгцээ шаардлага болон санал хүсэлтийг тусга.

· #УурАмьсгалынӨөрчлөлт болон #КОВИД-19 нь БҮХ хүнийг усны аюулгүй байдлаар хангах яаралтай хэрэгцээ шаардлагыг харуулж байна.

· НҮБ дэлхий даяар 5 хүн тутмын 2 нь гэртээ гар угаах саван болон усаар хангагдаагүй байна гэжээ. #КОВИД-19-ын цартахлын хүрээнд гараа угаах нь хамгийн чухал энэ үед хүн бүрт устай байх #хүнийэрх-ийг эдлүүлэх нь эн тэргүүний зорилт болж байна.

· Дэлхийн дулаарлыг Цельсийн 2 хэмээс доош барихын тулд хүчин чармайлт гаргахгүй бол 2050 он гэхэд усны хямралд өртөх хүний тоо хоёр дахин өснө гэсэн тооцоо бий. Шатах ашигт малтмалаас яг одоо татгалз.

· Өнөөдөр 3 хүн тутмын 2 нь жилд наад зах нь сарын хугацаанд усны хомсдол амсч байна. Усны нөөц бололцоог тогтвортой бөгөөд эрх тэгш байдлаар менежмэнт хийх цаг нь болсон.

· Усны менежмэнтийг сайжруулах нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулж, дасан зохицоход чухал юм. Дэлхий даяар устай харьцах ажлын 70 хувийг хариуцдагийн хувьд эмэгтэйчүүд усны хүртээмж, менежмэнт болон засаглалд голлох үүрэг гүйцэтгэх болно.